

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань Увс” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн
аудитын тайлан

Увс аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань Увс” ХХК-ийн 2021 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/07/-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Увс аймгийн Улаангом сум
2022 он

Цахим хуудас: uvs@audit.gov.mn

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799 Цахим хаяг:
Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн “Увс Финанс аудит”
ХХК аудитор: Я.Тунгалаг

Утас: 99459698 Цахим хаяг:
anuganzorig85@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Товчилсон үгийн жагсаалт.....	2
2.Аудитын санал дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6-7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7-8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8-9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	11
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11-12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13-16
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Дотоод хяналт.....	17
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
4.4 Материаллаг байдал	17
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	18
6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
7. Аудитын илрүүлэлт	19
7.1 Залруулсан алдаа.....	19
7.3 Албан шаардлага.....	20
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

НИЙТИЙН АЖ АХУЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ЧАНДМАНЬ
УВС" ХХК-ийн ЗАХИРАЛ
Б.ЦЭЦЭЭ ТАНАА

2022.03.15 № 37А-2022/071НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Увс аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК нь ТУЗ-ийн хууль эрх зүйн үндэслэлээ тодорхой заагаагүй 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 23 дугаар тогтоолыг үндэслэн 2021 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал гаргаж 10 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжид 17,908.0 мянган төгрөгийг олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 5.5 дахь заалт "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41 дүгээр 41.2.2 дахь заалтад "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", "Чандмань-Увс" ХХК-ийн ТУЗ-ын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан "Зардлын нэгдсэн төлөвлөгөө"-ний заалттай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" мэдэгдлийг хангахгүй байна.

0200200580

Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>681,358,628.55</u>	<u>688,806,324.03</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	295,842,489.35	183,684,905.99
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	768,772.47	5,329,030.42
31110	Төгрөг	768,772.47	5,329,030.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	295,073,716.88	178,355,875.57
3121	Төгрөг	295,073,716.88	178,355,875.57
31213	Арилжааны банк дахь харилцах	295,073,716.88	178,355,875.57
33	АВЛАГА	129,455,347.27	219,356,680.08
33401	Дансны авлага /ТӨҮГ/	129,455,347.27	219,356,680.08
34	УРЬДЧИЛГАА	75,941,761.00	99,941,761.00
34600	Урьдчилж гарсан зардал	75,941,761.00	99,941,761.00
35	БАРАА МАТЕРИАЛ	180,119,030.93	185,822,976.96
354	Хангамжийн материал	180,119,030.93	185,822,976.96
35420	Аж ахуйн материал	161,315,547.61	163,404,943.64
35470	Бусад хангамжийн материал	18,803,483.32	22,418,033.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,481,700,054.55</u>	<u>8,568,423,840.07</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	200,000.00	200,000.00
372	Үнэт цаас	200,000.00	200,000.00
37210	Төгрөг	200,000.00	200,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,481,500,054.55	8,568,223,840.07
392	Биет хөрөнгө	6,861,130,498.45	6,949,524,414.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,713,106,686.21	1,849,024,885.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(222,753,813.72)	(286,674,278.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	453,861,870.27	453,861,870.27
39204	Хуримтлагдсан элэгдэл	(274,331,722.26)	(309,719,703.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,316,229,023.40	6,651,544,372.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,205,132,070.08)	(1,487,529,445.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,162,922.96	39,242,922.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,204,383.33)	(27,418,192.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,191,985.00	67,191,985.00
393	Биет бус хөрөнгө	6,107,059.70	4,436,928.86
39301	Програм хангамж	8,536,000.00	8,536,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,679,333.26)	(5,599,333.18)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,251,964.00	11,251,964.00

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн
аудитын тайлан

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	271,922,152.81	297,448,146.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,864,726.52	219,481,837.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,864,726.52	219,481,837.76
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	217,864,726.52	219,481,837.76
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	217,864,726.52	219,481,837.76
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,057,426.29	77,966,309.10
2200	Дотоод эх үүсвэрээр	54,057,426.29	77,966,309.10
225105	Бусад ашиг (алдагдал) /ТӨҮГ/	54,057,426.29	77,966,309.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	29,633,168.29	(245,896,642.09)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	29,633,168.29	(245,896,642.09)
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	301,555,321.10	51,551,504.77

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,773,787,847.34	1,806,866,259.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,773,787,847.34	1,806,866,259.05
120	Нийтлэг татварын бус орлого	1,773,787,847.34	1,806,866,259.05
120009	Бусад орлого	662,312,861.34	200,565,072.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,108,077,919.00	1,600,273,008.05
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	3,397,067.00	6,028,179.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,599,852,282.70	1,809,075,422.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,599,852,282.70	1,809,075,422.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,599,852,282.70	1,809,075,422.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,463,007.90	538,514,364.90
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	506,463,007.90	538,514,364.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,748,299.00	170,155,090.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	140,748,299.00	170,155,090.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,683,912.91	151,536,179.21

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	282,280,452.00				282,280,452.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
16	Тайлант үеийн үр дүн			-245,896,642.09		-245,896,642.09
17	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,033,224,513.58	500,496,180.38	-978,042,658.65	1,619,316,571.41	8,174,994,606.72

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 он		Зөрүү
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Цалин	535,007.00	599,600.70	622,716.40	(23,115.70)
2	НДШ, ЭМДШ	72,201.50	86,942.10	88,710.30	(1,768.20)
3	Цахилгаан эрчим хүч	70,965.80	71,047.00	74,816.80	(3,769.80)
4	Дулаан	-	25,005.60	-	25,005.60
5	Хөдөлмөр хамгаалал	3,028.90	25,658.20	13,300.10	12,358.10
6	Сэлбэг хэрэгсэл	15,227.70	16,130.00	20,530.50	(4,400.50)
7	Түлш нүүрс	12,986.10	13,480.00	12,347.20	1,132.80
8	Материал түүхий эд	35,701.80	23,274.00	204,298.20	(181,024.20)
9	Албан томилолт, унаа	2,598.60	4,000.00	2,107.00	1,893.00
10	Тээврийн хэрэгслийн татвар, агаарын бохирдолын татвар, оношлогоо	689.10	796.50	753.50	43.00
11	Газрын татвар	7,652.90	7,695.00	10,643.70	(2,948.70)
12	Холбоо, бичиг хэрэг, хэвлэл захиалга	6,147.70	7,361.90	8,022.50	(660.60)
13	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	250,699.80	372,708.80	393,843.58	(21,134.78)
14	Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,098.80	8,098.80	10,278.50	(2,179.70)
15	Хөрөнгө, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгал,	1,586.90	1,650.00	3,131.70	(1,481.70)

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК нь Улаангом сумын айл өрх, аж ахуйн нэгжийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах, экологийн тэнцвэрт нийцсэн бохирыг байгальд нийлүүлэх зорилготой. Усан хангамж, ариутгах татуурга, нийтийн халуун усаар хангах чиг үүрэгтэй бөгөөд компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Иргэд, байгууллага аж ахуйн нэгжийг стандартын шаардлага хангасан унд ахуйн болон технологийн хэрэгцээний цэвэр усаар байнга тасралтгүй хангах, чанарын хяналт тавих.
- Хот суурины бохир усыг стандарт шаардлагын дагуу цэвэрлэж зайлуулах
- Орон сууцны барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ хийх
- Нийтийн халуун усны үйлчилгээ
- Үндсэн үйл ажиллагаанаас гадна улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан хулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагааг явуулж орлого ашгаа нэмэгдүүлэх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийг өмчит аж ахуйн нэгж ХХК гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

1951 онд байгуулагдаж "Үйлчлэх товчоо" нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, 1997 оны 3 сарын 14-нд Чандмань-Увс ХХК-ийг 01 тоот тогтоол үндэслэн байгуулсан байна.

Увс аймгийн Засаг даргын захирамжаар Компанийн удирдлагын 2021 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн Б/04 тоот захирамжаар томилсон байна. ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 2020 оны 7 дүгээр сарын 30-ны өдрийн Б/42 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын тамгын газрын хууль зүйн хэлтсийн дарга, бусад хэлтсүүдийн мэргэжилтнүүдээс бүрдсэн нийт 5 гишүүнтэйгээр томилсон байна. ТУЗ-ын 1 гишүүнийг 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн А/70 тоот тогтоолоор өөрчлөн томилжээ. ТУЗ нь 2021 онд 3 удаа хуралдаж 17 асуудал хэлэлцэж, 15 тогтоол, 1 албан бичиг гаргасан байна.

ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтай нийцэж байна. 2021 онд ТУЗ-ийн цалин урамшууллын зардалд 5,500.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 5,070.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Монгол улсын Засгийн газраас авах усны үнийн хөнгөлөлтийн 150,660.4 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсоныг авлагаар тайлагнасан байна. Үүнээс 18 сумын ус түгээх аж ахуйн нэгж байгууллагад олгох 26,626.4 мянган төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгасан байна.

Сумдын ус түгээх аж ахуйн нэгжийн төлбөрийн тооцоог олгохдоо усны тоолуурын заалтыг сумын Байгаль орчны байцаагч болон Санхүү төрийн сангийн мэргэжилтнүүд хянаж зарцуулалтын мэдээг тайланг Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-д ирүүлж хянуулан санхүүжилтийг сумдын Төрийн сангийн дансаар дамжуулан олгосон байна.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК нь цэвэр усны хэрэглээг сар бүр хөнгөлөлтөд хамрагдсан айл өрх, аж ахуйн нэгж байгууллага бүрээр тооцоог гаргаж мэдээ тайланг холбогдох байгууллагад өгсөн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	681,358,628.55	688,806,324.03	(7,447,695.48)
МӨНГӨН ХӨРӨНГӨ	295,842,489.35	183,684,905.99	112,157,583.36
АВЛАГА	129,455,347.27	219,356,680.08	(89,901,332.81)
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	75,941,761.00	99,941,761.00	(24,000,000.00)
БАРАА МАТЕРИАЛ	180,119,030.93	185,822,976.96	(5,703,946.03)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,481,700,054.55	8,568,423,840.07	(86,723,785.52)
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	200,000.00	200,000.00	-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,481,500,054.55	8,568,223,840.07	(86,723,785.52)
БИЕТ ХӨРӨНГӨ	6,861,130,498.45	6,949,524,414.81	(88,393,916.36)
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	6,107,059.70	4,436,928.86	1,670,130.84
БУСАД ХӨРӨНГӨ	1,614,262,496.40	1,614,262,496.40	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,163,058,683.10	9,257,230,164.10	(94,171,481.00)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,024,447,886.29	1,082,235,557.38	(57,787,671.09)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	78,879,686.29	136,667,357.38	(57,787,671.09)

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,439,682.8 мянган төгрөг буюу өмнөх оноос 159,823.8 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө оруулалтын ажил буурсантай холбоотой байна. Бусад орлого буюу тендерийн үйл ажиллагаанаас 295,777.1 мянган төгрөг авсан, тайлант онд 68 айлын орон сууц ашиглалтад орж 68 өрх, гэр хорооллын 224 айл шинээр нэмэгдсэн нь орлого өсөхөд нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 90,179.9 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна. Энэ нь ажилтнуудын цалингийн сүлжээнд өөрчлөлт орж цалин нэмэгдсэн, НДШ-ийн хувь хагас жилээс 14.5 хувь болж нэмэгдсэн, урсгал засварын ажил гүйцэтгэсэн, шинээр баригдсан ухаалаг худгийн гэрэл цахилгааны зардал өссөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн болно.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөл, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3.20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 66.0 сая төгрөгийн 2 ажлыг хасаж, 52.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэхээр өөрчлөлт оруулсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

2021 онд нийт үйл ажиллагаанаас 926,088.0 мянган төгрөгийн орлого олж, 1,439,958.2 мянган төгрөгийн зардал гаргаж, 513,870.2 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж ТУЗ-аар батлуулсан байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 1,144,205.7 мянга, бусад үйл ажиллагаанаас 295,777.1 мянга, нийт 1,439,982.8 мянга төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 1,685,879.0 мянган төгрөгийг зарцуулж 245,896.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 513,894.8 мянган төгрөгөөр давуулан биелэгдсэн нь тендерийн орлогоор 295,777.1 мянга, шугамын өргөтгөл хийгдэж

**Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн
аудитын тайлан**

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна .

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын албан бүхий чиг үүрэгтэй комисс томилж журам гаргасан хэдий ч тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байгаа тул аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,439,682.8 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 7,198.4 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,439,682.8 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 7,198.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,758.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,671,212.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,653,304.2 мянган төгрөгийн тайлагналтай холбоотой алдааг залруулж, 17,908.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага тогтоов.

Залруулагдаагүй 17,908.0 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 5,758.7 мянган төгрөгийн түвшнээс 12.122.3 мянган төгрөгөөс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,653,304.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Үнэн зөв байх", 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтад "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна" 8.1.5 дахь заалт "санхүүгийн тайлангийн тодруулга" гэж заасныг тус тус зөрчин санхүүгийн тайлангийн тодруулга тайланд авлагын дансны 6,946.4 мянга, үндсэн хөрөнгийн дансанд газрын дансны 1,618,699.4 мянган төгрөгийн үлдэгдлийг дутуу тайлагнасан алдаа зөрчлийг тус тус залруулав.
2. Аймгийн ИТХ-ын 2021 оны А/160 дугаар тогтоолоор 27,658.4 төгрөгийн үнэ бүхий Тоосгоны үйлдвэрийг акталж данс бүртгэлээс хасах шийдвэр гарсныг хэрэгжүүлээгүй байсан зөрчлийг залруулав.

8.2 Албан шаардлага

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 5.5 дахь заалтад "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, "Чандмань-Увс" ХХК-ийн ТУЗ-ын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан "Зардлын нэгдсэн төлөвлөгөө"-д заасныг тус тус зөрчин Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК нь ТУЗ-ийн хууль эрх зүйн үндэслэлээ тодорхой заагаагүй 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 23 дугаар тогтоолыг үндэслэн 2021 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал гаргаж компанийн захирлаар ажиллаж байсан М.Мөнхөөд 10 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжид 17,908.0 мянган төгрөгийг олгосонд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн
аудитын тайлан

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК	3	1,671,212.2	2	1,653,304.2	0	0	1	17,908.0	0	0


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



БЭЛТГЭСЭН:

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР

/Я.ТУНГАЛАГ/

2021 оны 3-р сарын 15-ны өдөр